



БҮРЭЛДЭХҮҮН, САЛБАР СУРГУУЛИЙН ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ НИЙТЛЭГ УДИРДАМЖ

Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нь тухайн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах Удирдамжийг энэхүү нийтлэг удирдамжид нийцүүлэн боловсруулж батална.

Ректорын тушаалаар батлагдсан тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комисс нь удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, үр дүнгийн тайлан, холбогдох материалыг Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

Тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулиудын тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах комисс бүр тэнхимийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтын зарыг өөрсдөө боловсруулж, нийтэд хүргэх ба ШУТИС-ийн албан ёсны вэб хуудаст заавал байршуулна. Бусад вэб хуудас, сошиал сувгууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан зар түгээх нь нээлттэй. Зар байршуулах хугацаа ажлын 5 өдрөөс багагүй байна.

Сонгон шалгаруулалтын комисс тус бүр дотроо хэлэлцэж, нарийн бичгийн даргаар их сургуулийн захиргаанаас томилогдсон төлөөллөөс бусад аль нэг гишүүнийг сонгоно.

Сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа: 2025.05.19 – 2025.05.30

Сонгон шалгаруулалтад баримтлах нийтлэг зарчим:

Тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хүний эрх, нэр төр, мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгavarлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, нээлттэй ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

Нэр дэвшигчид тавих шаардлага:

А. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигч нь дараах шалгуур, шаардлагыг хангасан байна.

1. Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй;
2. Тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;
3. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан;
4. Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;
5. Мэргэжлийн чиглэлээр салбartaа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэх чадвартай;

Б. Нэр дэвшигчийг тухайн их сургуулийн профессор, багшаар хязгаарлахгүй бөгөөд дээрх шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн сонгон шалгаруулалтад оролцох боломжтой.

В. Сонгон шалгаруулалтад оролцогч зөвхөн нэг тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвших эрхтэй.

Нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг:

А. Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гараар бичсэн хүсэлт;
2. Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкет);
3. Иргэний үнэмлэхийн хуулбар (E-mongolia системээс авсан лавлагаа);



ШУТИС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын
16-ний өдрийн 5 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

4. Боловсролын түвшин, эрдмийн зэрэг цолыг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах)-ийн хуулбар;
5. Ажлын туршлагын шаардлагыг хангасан тухай нотлох баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр г.м.)-ийн хуулбар, лавлагаа;
6. Бүтээлийн жагсаалт;
7. Тэнхимийг хөгжүүлэх морийн хотолбор. Морийн хотолбор нь дараах агуулгатай байна. Үүнд:
 - 7.1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-ний стратегийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээнд тухайн Тэнхимд хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
 - 7.2. Тэнхимиийн хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанар, материаллаг баазыг дээшлүүлэх, хөтөлбөр хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 7.3. Тэнхимиийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, мэргэжлийн үйлчилгээ болон оюутны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 7.4. Тухайн тэнхимиийн хөгжлийг хангахад чиглэсэн өөрийн санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, төсөл, хөтөлбөр;
 - 7.5. Хөтөлбөрийг 3 жилээр боловсруулсан байна.

Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.

Б. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл хангасан эсэх, нэр дэвшигч нь тавигдсан шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэх, боловсруулсан мөрийн хөтөлбөр нь дээр дурдсан агуулгатай нийцэж байгаа эсэхийг нягтална.

В. Нэр дэвшигч нь дээр заасан шалгуур шаардлагыг хангагүй, бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Сонгон шалгаруулалтын үр дүн, шийдвэр гаргалт:

1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусахад Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны тайлан, хурлын тэмдэглэл, шалгарсан нэр дэвшигчийн холбогдох материалын төслийн хуудсууд болон бусад баримт бичгийг нэгтгэн 2025.06.02-ны дотор Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
2. Захиргааны удирдлагын газар бүрэлдэхүүн, салбар сургуулиудын ирүүлсэн материалыг нэгтгэн, үр дүнг Ректорт танилцуулсандаа Ректор тэнхимиийн эрхлэгчдийг томилно. Шаардлагатай тохиолдолд тухайн комисс, нэр дэвшигчээс нэмэлт мэдээлэл, тодруулга авч болно.
3. Хэрэв сонгон шалгаруулалтад оролцохор нэг ч иргэн материал ирүүлээгүй бол тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал тэнхимиийн эрхлэгчийн албан тушаалын шаардлага хангасан нэр дэвшигчдийг Ректорт санал болгоно. Ректор санал болгосон нэр дэвшигчдийн холбогдох материалын танилцаж, ярилцлага хийсний үндсэн дээр сонгож, сонгогдсон нэр дэвшигчийг тэнхимиийн эрхлэгчээр томилно.

Маргаан, гомдол шийдвэрлэх: Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргаан, гомдлыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сонгон шалгаруулалтын комисс зохих журмын хүрээнд шийдвэрлэнэ.